



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ховд аймгийн Жаргалант сумын Цаст-Алтай сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2026/145/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Ховд хот  
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061 Цахим хаяг:  
[boldbaatarkhu@audit.gov.mn](mailto:boldbaatarkhu@audit.gov.mn)

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545 Цахим  
хаяг: [tsetsegsurena@audit.gov.mn](mailto:tsetsegsurena@audit.gov.mn)

Ахлах аудитор: Ц.Бадрал

Утас: 70432545  
Цахим хаяг: [badralts@audit.gov.mn](mailto:badralts@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

<b>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ</b> .....	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	9
<b>3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ</b> .....	9
3.1 Төлбөрийн акт .....	10
3.2 Зөвлөмж .....	10
<b>4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ</b> .....	12

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Жаргалант сумын Цаст-Алтай сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд 3 сурагч 800 оноо, 4 сурагч 750-аас дээш оноо авч 2025 оны ЭШ-ийн дундаж оноогоор аймагт I байранд шалгарсан, байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээгээр 4 дүгээр түвшинд үнэлэгдэж 31,503.9 мянган төгрөгийн урамшуулал авсан байна.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд цалин хөлсний зардалд 3,825,260.1 мянган төгрөгийг зарцуулсан нь өнгөрсөн оны гүйцэтгэлээс 20.4 хувиар, үдийн хоолны зардалд 295,883.1 мянган төгрөг, түлш халаалтын зардалд 448,860.3 мянган төгрөг, гэрэл цахилгааны зардалд 22,714.2 мянган төгрөгийг зарцуулсан нь 2024 оны гүйцэтгэлтэй

харьцуулахад 34.4 хувиар өссөн нь хүүхдийн хоолны зардлын норматив, цахилгаан, халаалтын тарифын үнэ өссөнтэй холбоотой байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Тайлант онд гүйцэтгэлийн төлөвлөгөөг 6 зорилтын хүрээнд 86 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн гүйцэтгэлийг тооцон дээд шатны байгууллагад хүргүүлсэн байна.

2025 онд хийсэн багшийн гүйцэтгэлийн үнэлгээгээр I түвшний багш -2, II түвшний багш -11, III түвшний багш -17, бусад багш нар IV түвшний багш -13 үнэлэгдсэн байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.БОЛДБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>611,046,126.53</u></b>	<b><u>734,330,820.14</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>295,502,435.48</b>	<b>362,422,932.16</b>
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>295,502,435.48</b>	<b>362,422,932.16</b>
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	<b>295,502,435.48</b>	<b>362,422,932.16</b>
31211	Төрийн сангийн харилцах	295,502,435.48	362,422,932.16
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>-</b>	<b>17.93</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	17.93
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>315,543,691.05</b>	<b>371,907,870.05</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>911,880.00</b>	<b>991,170.00</b>
35130	Эм боох материал	911,880.00	991,170.00
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	900,000.00	900,000.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	-	52,800.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>265,446,416.33</b>	<b>318,280,267.63</b>
35410	Бичиг хэргийн материал	9,162,794.00	21,097,059.00
35420	Аж ахуйн материал	24,616,907.00	81,377,831.00
35430	Сэлбэг хэрэгсэл	399,255.00	399,255.00
35440	Түлш, шатах тослох материал	22,751,240.00	22,751,240.00
35460	Хүнсний материал	20,005,410.00	631,010.00
35470	Бусад хангамжийн материал	188,510,810.33	192,023,872.63
35600	Мал амьтад	48,285,394.72	51,683,632.42
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>6,156,671,069.05</u></b>	<b><u>5,927,305,507.78</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>6,156,671,069.05</b>	<b>5,927,305,507.78</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>5,881,258,458.65</b>	<b>5,653,952,550.03</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,999,568,584.43	5,999,568,584.43
39202	Хуримтлагдсан элэгдэл	(714,175,508.77)	(856,687,044.73)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	725,286,052.18	760,821,562.18
39206	Хуримтлагдсан элэгдэл	(349,335,945.65)	(474,899,291.65)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	347,896,713.62	397,082,988.62
39208	Хуримтлагдсан элэгдэл	(180,920,173.60)	(223,928,123.76)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	4,800,000.00	4,800,000.00
39217	Ном	48,138,736.44	47,193,874.94
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>275,412,610.40</b>	<b>273,352,957.75</b>
39301	Программ хангамж	10,449,175.00	10,449,175.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,210,564.60)	(4,270,217.25)
39303	Бусад биет бус хөрөнгө	267,174,000.00	267,174,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>6,767,717,195.58</u></b>	<b><u>6,661,636,327.92</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>18,054,000.00</u></b>	<b><u>7,638,200.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>18,054,000.00</b>	<b>7,638,200.00</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	<b>18,054,000.00</b>	<b>7,638,200.00</b>
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	<b>18,054,000.00</b>	<b>7,638,200.00</b>

41361	Байгууллагад төлөх өглөг	18,054,000.00	7,638,200.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>6,749,663,195.58</u></b>	<b><u>6,653,998,127.92</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b><u>6,749,663,195.58</u></b>	<b><u>6,653,998,127.92</u></b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,146,187,550.49	1,146,187,550.49
51101	Өмч: - төрийн	1,146,187,550.49	1,146,187,550.49
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b><u>4,685,929,073.00</u></b>	<b><u>4,590,264,005.34</u></b>
51210	Өмнөх үеийн үр дүн	4,685,929,073.00	4,685,929,073.00
51220	Тайлант үеийн үр дүн	-	(95,665,067.66)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	917,546,572.09	917,546,572.09
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>6,767,717,195.58</u></b>	<b><u>6,661,636,327.92</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b><u>5,303,444,215.62</u></b>	<b><u>5,733,154,726.00</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b><u>938,375,315.62</u></b>	<b><u>120,215,626.00</u></b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b><u>473,292,415.62</u></b>	<b><u>120,215,626.00</u></b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	473,292,415.62	120,215,626.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,615,600.00	11,958,900.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	227,405,251.00	69,449,600.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	230,271,564.62	38,807,126.00
<b>123</b>	<b>Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг</b>	<b><u>465,082,900.00</u></b>	-
123004	Улсын төсвөөс орон нутгийн төсвөөс төвлөрүүлэх шилжүүлэг	465,082,900.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b><u>4,365,068,900.00</u></b>	<b><u>5,612,939,100.00</u></b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b><u>4,365,068,900.00</u></b>	<b><u>5,034,538,700.00</u></b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,365,068,900.00	5,034,538,700.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	-	<b><u>578,400,400.00</u></b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	578,400,400.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b><u>5,066,670,091.38</u></b>	<b><u>5,817,255,132.16</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b><u>5,066,670,091.38</u></b>	<b><u>5,817,255,132.16</u></b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b><u>4,774,949,824.82</u></b>	<b><u>5,481,278,963.09</u></b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b><u>3,201,256,091.54</u></b>	<b><u>3,855,520,710.17</u></b>
210101	Үндсэн цалин	2,245,372,525.54	2,459,575,986.17
210102	Нэмэгдэл	818,384,802.00	1,176,868,259.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	57,082,196.00
210104	Урамшуулал	137,498,764.00	161,994,269.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b><u>397,773,084.67</u></b>	<b><u>482,420,624.28</u></b>
210201	Тэтгэврийн даатгал	267,817,184.67	316,099,598.28
210202	Тэтгэмжийн даатгал	32,488,900.00	41,014,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	16,244,500.00	20,507,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	16,244,500.00	22,770,226.00
210205	Эрүүл мэндийн даатгал	64,978,000.00	82,029,100.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b><u>535,457,839.44</u></b>	<b><u>572,476,180.93</u></b>
210301	Гэрэл, цахилгаан	14,908,813.44	24,193,057.93

210302	Түлш, халаалт	448,865,306.00	448,860,323.00
210303	Цэвэр, бохир ус	71,683,720.00	99,422,800.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>-</b>	<b>21,836,391.00</b>
210408	Бараа материал ақталсны зардал	-	21,836,391.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,480,000.00</b>	<b>-</b>
210604	Урсгал засвар	1,480,000.00	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>105,805,039.46</b>	<b>95,794,899.94</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,600,700.00	11,958,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	90,204,339.46	83,835,999.94
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>533,177,769.71</b>	<b>453,230,156.77</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	215,221,482.67	139,587,672.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	45,885,770.00	500,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	272,070,517.04	313,142,484.77
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>291,720,266.56</b>	<b>335,976,169.07</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>288,208,600.00</b>	<b>335,951,950.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	226,423,500.00	315,468,550.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	61,785,100.00	20,483,400.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>3,511,666.56</b>	<b>24,219.07</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,511,666.56	24,219.07
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>236,774,124.24</b>	<b>(84,100,406.16)</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>-</b>	<b>11,564,661.50</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	11,564,661.50
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-</b>	<b>(11,564,661.50)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>236,774,124.24</b>	<b>(95,665,067.66)</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(Төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,146,187,550.49	917,546,572.09	4,685,929,073.00	6,749,663,195.58
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,146,187,550.49	917,546,572.09	4,685,929,073.00	6,749,663,195.58
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,146,187,550.49	917,546,572.09	4,685,929,073.00	6,749,663,195.58
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(95,665,067.66)	(95,665,067.66)
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,146,187,550.49	917,546,572.09	4,590,264,005.34	6,653,998,127.92

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(Төгрөгөөр)

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	5,073,227,481.00	5,694,347,600.00

<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>708,103,751.00</b>	<b>81,408,500.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>243,020,851.00</b>	<b>81,408,500.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	243,020,851.00	81,408,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,615,600.00	11,958,900.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	227,405,251.00	69,449,600.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	465,082,900.00	
123004	Улсын төсвөөс орон нутгийн төсвөөс төвлөрүүлэх шилжүүлэг	465,082,900.00	
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>4,365,123,730.00</b>	<b>5,612,939,100.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>4,365,068,900.00</b>	<b>5,034,538,700.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,365,068,900.00	5,034,538,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>		<b>578,400,400.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/		578,400,400.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>54,830.00</b>	
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	54,830.00	
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>4,935,480,920.34</b>	<b>5,552,038,403.32</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>4,935,480,920.34</b>	<b>5,552,038,403.32</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>4,637,321,203.78</b>	<b>5,235,647,684.25</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>3,201,256,091.54</b>	<b>3,825,260,052.38</b>
210101	Үндсэн цалин	2,111,597,043.54	2,181,994,984.38
210102	Нэмэгдэл	919,103,662.00	1,362,300,030.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		63,127,196.00
210104	Урамшуулал	170,555,386.00	217,837,842.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>397,773,084.67</b>	<b>512,681,300.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	270,183,994.00	348,623,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	30,122,090.67	41,014,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	16,244,500.00	20,507,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	16,244,500.00	20,507,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	64,978,000.00	82,029,100.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>448,871,233.44</b>	<b>572,476,180.93</b>
210301	Гэрэл, цахилгаан	14,908,813.44	24,193,057.93
210302	Түлш, халаалт	362,278,700.00	448,860,323.00
210303	Цэвэр, бохир ус	71,683,720.00	99,422,800.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>10,900,000.00</b>	<b>5,900,000.00</b>
210604	Урсгал засвар	10,900,000.00	5,900,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>242,054,664.86</b>	<b>95,954,899.94</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	145,088,808.00	11,958,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	96,965,856.86	83,995,999.94
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>336,466,129.27</b>	<b>223,375,251.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	298,452,029.27	197,919,251.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	38,014,100.00	25,456,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>298,159,716.56</b>	<b>316,390,719.07</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>294,648,050.00</b>	<b>316,366,500.00</b>

213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	54,830.00	
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	232,808,120.00	295,883,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	61,785,100.00	20,483,400.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>3,511,666.56</b>	<b>24,219.07</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,511,666.56	24,219.07
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>137,746,560.66</b>	<b>142,309,196.68</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>		<b>75,388,700.00</b>
	Дотоод эх үүсвэрээр		75,388,700.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		75,388,700.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>		<b>-75,388,700.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>137,746,560.66</b>	<b>66,920,496.68</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>157,755,874.82</b>	<b>295,502,435.48</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>295,502,435.48</b>	<b>362,422,932.16</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(Төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>6,008,074,900.00</b>	<b>5,627,402,884.25</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>6,008,074,900.00</b>	<b>5,627,402,884.25</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>5,640,290,500.00</b>	<b>5,311,036,384.25</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>4,133,449,800.00</b>	<b>3,825,260,052.38</b>
210101	Үндсэн цалин	2,475,854,000.00	2,181,994,984.38
210102	Нэмэгдэл	1,482,437,700.00	1,362,300,030.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	63,127,196.00
210104	Урамшуулал	175,158,100.00	217,837,842.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>517,188,900.00</b>	<b>512,681,300.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	351,688,500.00	348,623,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	41,375,100.00	41,014,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	20,687,500.00	20,507,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	20,687,500.00	20,507,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	82,750,300.00	82,029,100.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>572,500,400.00</b>	<b>572,476,180.93</b>
210301	Гэрэл, цахилгаан	24,211,300.00	24,193,057.93
210302	Түлш, халаалт	448,866,300.00	448,860,323.00
210303	Цэвэр, бохир ус	99,422,800.00	99,422,800.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>5,900,000.00</b>	<b>5,900,000.00</b>
210604	Урсгал засвар	5,900,000.00	5,900,000.00

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>99,381,200.00</b>	<b>95,954,899.94</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,229,000.00	11,958,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	87,152,200.00	83,995,999.94
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>311,870,200.00</b>	<b>298,763,951.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	286,414,200.00	273,307,951.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	25,456,000.00	25,456,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>367,784,400.00</b>	<b>316,366,500.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>367,784,400.00</b>	<b>316,366,500.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	347,301,000.00	295,883,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	20,483,400.00	20,483,400.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>6,008,074,900.00</b>	<b>5,694,323,380.93</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>5,340,925,500.00</b>	<b>5,034,538,700.00</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	5,053,038,900.00	5,034,538,700.00
131009	Урьд оны үлдэгдлээс	287,886,600.00	
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>578,400,400.00</b>	<b>578,376,180.93</b>
132001	Орон нутгийн төсвөөс	578,400,400.00	578,376,180.93
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>88,749,000.00</b>	<b>81,408,500.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12,229,000.00	11,958,900.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	76,520,000.00	69,449,600.00
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>295,502,435.48</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>362,422,932.16</b>

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Нэмэлт санхүүжилтийн гүйлгээ хийгдээгүй болно.

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 48,334.7 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 50,295.0 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа<sup>1</sup>-г залруулж, баталгаажуулав. Үүнд:

- ✓ Бараа материалын дансанд үндсэн хөрөнгийг бүртгэсэн – 1,544.9 мянган төгрөг,
- ✓ Үндсэн хөрөнгийг дутуу бүртгэсэн, элэгдэл дутуу тооцсон – 11,308.5 мянган төгрөг
- ✓ Үр дүнгийн тайланд зардлын зүйл ангийг зөрүүтэй тайлагнасан - 37,441.6 мянган төгрөг

Залруулагдаагүй нийт 7,083.4 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 7,083.4 мянган төгрөгийн 4 зөрчил<sup>2</sup> илэрснээс, 3,202.2 мянган төгрөгийн төлбөрийн акт, 3,881.3 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

### 3.1 Төлбөрийн акт

3.1.1 Байгууллагын удирдлага нь санхүүгийн ажилтнуудын ажлыг өмнөх онд хагас, бүтэн жилээр дүгнэн үр дүнгийн мөнгөн урамшууллыг тухай бүр тооцож олгосон боловч тус урамшуулалтай давхардуулан сургуулийн захирлын тушаалаар 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрчилгүй ажилласан гэх үндэслэлээр 1,242,153 төгрөгийн урамшуулал илүү олгоод буцаан суутгаагүй, авлагаар бүртгээгүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4-д “улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно” 15.1.3-д “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.2 дахь “Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэлт: Төлбөрийн акт тогтоов.

3.1.2 Түрээсийн орлогоос аймгийн өмчийн санд төвлөрүүлэх мөнгийг 1,960,000 төгрөгийг дутуу төвлөрүүлэн үйл ажиллагаандаа зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 49 дүгээр тогтоолын 2 дахь хэсэгт “түрээсийн орлогоос улсын төсөвт төвлөрүүлэх хэмжээг нийт орлогын дүнгийн 40 хувиар тогтоосугай” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэлт: Төлбөрийн акт тогтоов.

### 3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 3.2.1 Цалин хөлстэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Ур чадварын нэмэгдлийг Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайд нарын хамтарсан 2021 оны А/35 / А/10 / 9 дугаар тушаалаар баталсан ур чадварын нэмэгдэл олгох шалгуур тогтоосон журмын дагуу олгоогүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтын 3-д “Төрийн үйлчилгээний байгууллагын удирдах, гүйцэтгэх, туслах албан хаагчид төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлж байх хугацаанд нь ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг энэ журмын 4-т заасан шалгуур үзүүлэлтийн дагуу албан тушаалын сарын үндсэн цалингаас 10-25 хувиар тооцож, сар бүр олгоно”, БШУС, ХНХС, СС нарын хамтарсан А/35 А/10 /9 тушаалаар баталсан журмын 6-д “багш, ажилтны ур чадварыг хагас жил тутамд үнэлж, нэмэгдлийг сар бүр олгоно” гэж заасан заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлтийн дагуу гаргасан амжилтыг зөв үнэлэх сар бүрийн олгох хувь хэмжээний хязгаарт багтаан олгох.

#### 3.2.2 Цалин хөлстэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Сургуулийн нийгмийн ажилтан, хоол зүйч, сургалтын менежер гэх мэт ажилтнуудыг амралтын өдрөөр уралдаан тэмцээн, урлагийн арга хэмжээ зохион байгуулсан гэж илүү цагийн нэмэгдэл хөлс 3,881,255 төгрөг олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.1-д “илүү цагаар ажилласан ажилтныг нөхөн амруулаагүй

бол түүний дундаж цалин хөлсийг нэг аравны тав дахин, түүнээс дээш хэмжээгээр нэмэгдүүлж олгоно.”, 109.2-д ”долоо хоногийн амралтын өдөр ажилласан ажилтныг нөхөн амруулаагүй бол түүний дундаж цалин хөлсийг нэг аравны тав дахин, түүнээс дээш хэмжээгээр нэмэгдүүлж олгоно.” Засгийн газрын 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 3 дугаар зүйлийн 3-д “Илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласны нэмэгдэл хөлс тооцох цаг нь 4.1-т зааснаас бусад тохиолдолд тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрэхгүй байна.” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу ажилтнуудыг хичээл заахаас бусад тохиолдлоор илүү цагаар ажиллуулбал нөхөн амрах замаар шийдвэрлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэж заасны дагуу зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.

Шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж биелэлтийг Fas.audit.mn цахим системд нотлох баримтын хамт тайлагнан, Ховд аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### 4.1. Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								тоо	Дүн	тоо	Дүн		
1	2	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
Цаст-Алтай сургууль	Бараа материалын дансанд үндсэн хөрөнгийг бүртгэсэн	1	1,544.9	0	0	1	1,544.9	1	1,544.9	0	0	0	0
	Үндсэн хөрөнгийг дутуу бүртгэсэн, элэгдэл дутуу тооцсон	1	11,308.5	1	11,308.5			1	11,308.5	0	0	0	0
	Үр дүнгийн тайланд зардлын зүйл ангийг зөрүүтэй тайлагнасан	1	37,441.6			1	37,441.6	1	37,441.6	0	0	0	0
<b>Нийт дүн</b>		<b>3</b>	<b>50,295.0</b>	<b>1</b>	<b>11,308.5</b>	<b>2</b>	<b>38,986.5</b>	<b>3</b>	<b>50,295.0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>

##### 4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт	Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн		
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Цаст-Алтай сургууль	Байгууллагын удирдлага нь санхүүгийн ажилтнуудын ажлыг өмнөх онд хагас, бүтэн жилээр дүгнэн үр дүнгийн мөнгөн урамшууллыг тухай бүр тооцож олгосон боловч тус урамшуулалтай давхардуулан сургуулийн захирлын тушаалаар 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар	1	1,242.2	1	1,242.2	0	0	1	0	0	0

	зөрчилгүй ажилласан гэх үндэслэлээр урамшуулал олгоод буцаан суутгаагүй, авлагаар бүртгээгүй										
	Түрээсийн орлогоос аймгийн өмчийн санд төвлөрүүлэх мөнгийг дутуу төвлөрүүлэн үйл ажиллагаандаа зарцуулсан	1	1,960.0	1	1,960.0						
	Ур чадварын нэмэгдлийг Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайд нарын хамтарсан 2021 оны А/35 / А/10 / 9 дүгээр тушаалаар баталсан ур чадварын нэмэгдэл олгох шалгуур тогтоосон журмын дагуу олгоогүй	1	-				1		-		
	Сургуулийн нийгмийн ажилтан, хоол зүйч, сургалтын менежер, гэх мэт ажилтнуудыг амралтын өдрөөр уралдаан тэмцээн, урлагийн арга хэмжээ зохион байгуулсан гэж илүү цагийн нэмэгдэл хөлс олгосон	1	3,881.2				1		3,881.2		
<b>Нийт дүн</b>		<b>4</b>	<b>7,083.4</b>	<b>2</b>	<b>3,202.2</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>2</b>	<b>3,881.2</b>	<b>0</b>	<b>0</b>

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагталсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>			<b>1</b>			